



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН 40.9 ХУВИЙГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭС ШАЛТГААЛАН БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН, ХЭРЭГЖИЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 16.6 ХУВЬ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

**Аудитын нэр: УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Аудитын код: АРА-2026/05-1/ШТА-НА

Архангай аймаг 2026 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Н.Алтантуяа

Утас: 77332860 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Аудитор А.Пүрэвцэцэг

Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn



| | | |
|--|---|-------|
| Тайлан | ➤ Товчилсон үгийн тайлбар | 3-4 |
| бэлтгэсэн: | ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй | 5-7 |
| Архангай аймаг | ➤ Үндсэн мэдээлэл | 7 |
| дахь Төрийн | ➤ Аудитын тайлан | 8-23 |
| аудитын газар | | |
| Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа | БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДСАН БАЙНА | |
| Аудитын менежер Н.Алтантуяа | А.1. Архангай аймгийн хэмжээнд улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах 41 саналыг хүргүүлсэн байна | |
| Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ | А.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 6 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна | |
| Аудитор А.Пүрэвцэцэг | БҮЛЭГ Б. ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ШИНЭ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ ТУЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ БАЙНА | |
| 2026 оны 05 дугаар сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү. | Б.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжээгүй шинээр хэрэгжсэн 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг орон нутагт үзэх боломжгүй байна | |
| Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу | БҮЛЭГ В. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН 40.9 ХУВИЙГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭС ШАЛТГААЛАН БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН, ХЭРЭГЖИЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 16.6 ХУВЬ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА | |
| Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот | В.1. Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн санхүүжилтийн 40.9 хувийг зарцуулаагүй, 2025 онд дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 16.6 хувь нь хугацаандаа хэрэгжээгүй байна | |
| | В.2. Барилга байгууламжийн зарим материалын шаардлагад хяналт хэрэгжүүлээгүй, комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдаагүй байна | |
| | В.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж, ашиглалтад хүлээн авсан хөрөнгийн 80 хувийг бүрэн хүчин чадлаар зориулалтын дагуу ашиглаж байна | |
| | Дүгнэлт..... | 22 |
| | Зөвлөмж | 23 |
| | Холбогдох байгууллагын санал | 24 |
| | Тайлан баталгаажуулсан тушаал..... | 25-26 |
| | Хавсралт:Судалгаанууд | 26-34 |



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---------|---|
| АДБОУС | АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ |
| БОУАӨС | БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД |
| БС | БОЛОВСРОЛЫН САЙД |
| ХББОСС | ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД |
| ББАОК | БАРИЛГА БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИСС |
| ГА | ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ |
| ГАГ | ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР |
| ГХБХБГ | ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР |
| ЕБС | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ |
| ЗГХЭГ | ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР |
| ЗТС | ЗАМ ТЭЭВРИЙН САЙД |
| НТШ | НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ |
| ОНӨГ | ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР |
| СТСХ | САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС |
| ТАХ | ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ |
| ТЕЗ | ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ |
| УИХ | УЛСЫН ИХ ХУРАЛ |
| ҮАГ | ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР |
| ХААГ | ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР |
| ХХААХҮС | ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД |
| ХОХБТХ | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС |
| ЭМС | ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД |
| ЭХС | ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД |

Дүрслэлийн товъёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|--|-----------------|
| 1 | Нийт олгосон санхүүжилтийн хуваарилалт | 12 |
| 2 | Боловсролын салбарын хэрэгжсэн ТАХ | 18 |
| 3 | Ихтамир сумын дэд бүтэц | 19 |
| 4 | Эрдэнэмандал суманд хэрэгжсэн Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц | 19 |
| 5 | Эрдэнэмандал суманд хэрэгжсэн 0.4 кВ-ын шугамын трассын зураг | 20 |
| 6 | Өмнөх аудитаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилт | 23 |

Хүснэгтийн товъёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|-----------------|
| 1 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, барьцаа хөрөнгийн дансны судалгаа | 6 |
| 2 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, барьцаа хөрөнгийн дансны судалгаа | 6 |
| 3 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Архангай аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал | 8 |
| 4 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ бодлогын баримт бичигтэй уялдсан байдал | 8 |



| | | |
|----|--|----|
| 5 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ний ангилал, гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний тоо, гэрээний дүн | 10 |
| 6 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжээгүй хэрэгжсэн ТАХ-ний ангилал, гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний тоо, гэрээний дүн | 10 |
| 7 | Аймагт эрх шилжүүлсэн ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа | 11 |
| 8 | Аймагт эрх шилжээгүй ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа | 11 |
| 9 | Аймагт эрх шилжсэн ТАХ-ний гэрээний дүн болон магадлалаар өссөн төсөвтэй харьцуулсан зөрүү | 12 |
| 10 | Аймгийн хэмжээнд хэрэгжсэн эрх шилжсэн, шилжээгүй ТАХ-ний мэдээлэл, ангиллаар | 13 |
| 11 | Аймгийн хэмжээнд хэрэгжсэн ТАХ-ний ангилал | 16 |
| 12 | Ашиглалтад хүлээн авсан ТАХ-ний хүчин чадал, нягтлан бодох бүртгэл | 17 |
| 13 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 21 |
| 14 | Хэрэгжиж дууссан ТАХ-ний хүчин чадал, ашиглалт | 21 |
| 15 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжих ТАХ-ний зорилтот түвшин, бодит ажлын гүйцэтгэл | 22 |



АУДИТЫН НЭР:

“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

АУДИТЫН КОД: АРА-2026/05-1/ШТА-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” МУЕА-ын 2025 оны А/179 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад Архангай аймагт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХОХБТХ, аймгийн ГХБХБГ, ХААГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, түүвэрлэлт хийх, тулган баталгаажуулах, судалгаа авч нэгтгэх зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.





- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар
- ✓ Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- ✓ Архангай аймгийн ИТХ-ын тогтоолууд
- ✓ Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- ✓ Архангай аймгийн Засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Архангай аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө,
- ✓ Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд,
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Н.Алтантуяа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор А.Пүрэвцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2026.03.09-2026.05.01-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Гүйцэтгэлийн аудитын тайланг асуудлын шинжилгээний 3 дахь түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 2 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Архангай аймагт хэрэгжүүлэхээр өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 253,071.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээг 57,608.5 сая төгрөгөөр, шинээр 61,017.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээг 24,588.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр



баталсан байна. /Эх сурвалж: 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр өөрчлөн найруулж баталсан Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт/

Тайлант жилд 5 Сайдын багцаас аймгийн Засаг даргад өмнөх оноос үргэлжлүүлэх нийт 20 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлж **38,536.8** сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөснөөс 25,835.4 сая төгрөгийг аймгийн төрийн санд шилжүүлсэн байна. Төрийн сангаас ажлын гүйцэтгэлд үндэслэн **24,045.2** сая төгрөгийг гүйцэтгэгч нарт олгож, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 278 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/684 дүгээр захирамжаар 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдэл болох **1,790.2** сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, барьцаа хөрөнгийн дансны судалгаа

Хүснэгт 1. /сая.төгрөг/

| № | Харьяа Сайд | Хэрэгжсэн ТАХ-ний тоо | 2025 онд олгох санхүүжилт | Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт | Барьцаа хөрөнгийн дансанд |
|-----------------|------------------|-----------------------|---------------------------|---------------------------------|---------------------------|
| 1 | ЗТХСайд | 5 | 15,362.6 | 7,340.7 | 1,393.4 |
| 2 | Боловсролын Сайд | 9 | 12,453.0 | 11,885.9 | 241.5 |
| 3 | ХББОСС | 1 | 5,118.6 | - | - |
| 4 | ССАЖЗС | 3 | 3,171.9 | 2,720.5 | 114.0 |
| 5 | ЗГХЭГ | 2 | 2,430.7 | 2,098.1 | 41.3 |
| Нийт дүн | | 20 | 38,536.8 | 24,045.2 | 1,790.2 |

Харин 2025 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлээгүй 9 Сайд болон ШЕЗ-өөс шинээр болон өмнөх оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 120,677.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй **17** ТАХ-г 43,660.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Тайланд онд ТЕЗ-аас ажлын гүйцэтгэлд үндэслэн 24,741.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 18,918.6 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжээгүй төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, барьцаа хөрөнгийн дансны судалгаа

Хүснэгт 2. /сая.төгрөг/

| Харьяа Сайд | ТАХ-ний тоо | | 2025 онд олгох санхүүжилт | | Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт | | Үлдэгдэл |
|------------------|-------------|--------------------|---------------------------|--------------------|---------------------------------|--------------------|-----------------|
| | Шинэ | Өмнөх оноос шилжих | Шинэ | Өмнөх оноос шилжих | Шинэ | Өмнөх оноос шилжих | |
| ЗТХСайд | 1 | 2 | 17,989.4 | 10,006.1 | 4,746.0 | 6,156.6 | 17,092.9 |
| Боловсролын Сайд | - | 4 | - | 2,951.7 | - | 2,398.2 | 553.5 |
| БОУАӨС | - | 1 | - | 1,398.4 | - | 1,398.4 | - |
| ЭЗХС | 1 | - | 1,279.0 | - | 866.0 | - | 413.0 |
| ХББОСС | 1 | 1 | 51.8 | 2,689.1 | - | 2,673.2 | 67.7 |
| ЭХСайд | 1 | 1 | 1,703.8 | 627.0 | 1,687.1 | 602.2 | 41.5 |
| ССАЖЗС | - | 1 | - | 1,000.0 | - | 1,000.0 | - |
| ХХААХҮС | 1 | - | 94.8 | - | 94.8 | - | - |
| ЦХИХХС | - | 1 | - | 399.4 | - | 196.7 | 202.7 |
| ШЕЗ | 1 | - | 3,469.9 | - | 2,922.6 | - | 547.3 |
| Нийт дүн | 6 | 11 | 24,588.7 | 19,071.7 | 10,316.5 | 14,425.3 | 18,918.6 |
| | | | | 43,660.4 | | 24,741.8 | |



БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН 6 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТой УЯЛДСАН БАЙНА

А.1. Архангай аймгийн хэмжээнд улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах 41 саналыг хүргүүлсэн хэдий ч 1 төсөл, арга хэмжээ тусгагдсан байна

Архангай аймгийн Засаг даргаас 2025 онд хэрэгжүүлэх нийт 691,208.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 41 төсөл, арга хэмжээг эрэмбэлэн үнэлж, [/pimis.publicinvestment.gov.mn/](http://pimis.publicinvestment.gov.mn/) цахим системээр төлөвлөн саналыг аймгийн Засаг даргын 2024.06.25-ны өдрийн 01/987 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлжээ.

Хүргүүлсэн саналаас Монгол Улсын төсвийн тухай хуулиар тайлант онд санхүүжих дүн бүхий 689.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Өндөр-Улаан сумын Хануйн гүүрнээс Эрдэнэмандал сумын төв хүртэлх хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төсөв /Архангай, Өндөр-Улаан сум/” баталсан ба тус төсөл, арга хэмжээний эрхийг аймагт шилжүүлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Архангай аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал

Хүснэгт 3. /сая төгрөг/

| Харьяа Сайд | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|------------------|-------------|------------------|------------------|
| ЗТХСайд | 13 | 438,959.9 | 243,270.0 |
| Боловсролын Сайд | 6 | 38,820.0 | 24,200.0 |
| БОУАӨС | 1 | 253.0 | 253.0 |
| ЭЗХС | 1 | 41,420.7 | 21,000.0 |
| ХББОСС | 3 | 73,669.7 | 37,155.9 |
| ЭХСайд | 3 | 38,719.1 | 38,719.1 |
| ССАЖЗС | 2 | 3,210.0 | 1,600.0 |
| ЗГХЭГ | 2 | 6,092.4 | 4,000.0 |
| ЭМС | 10 | 50,064.0 | 32,500.0 |
| Нийт | 41 | 691,208.8 | 402,698.0 |

Аймгийн ТЭЗ-аас 9 Сайдын багцад 691,208.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 402,698.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 41 төсөл, арга хэмжээг эрэмбэлэн хүргүүлсэн хэдий ч 97.5 хувь буюу 40 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй нь орон нутагт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ орхигдох эрсдэл үүссэн байна.

А.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 6 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна

Монгол Улсын төсвийн тухай хуулиар Архангай аймагт 2025 онд эрх шилжээгүй шинээр хэрэгжих 61,017.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд 24,588.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг баталсан ба уг төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаж байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ бодлогын баримт бичигтэй уялдсан байдал

Хүснэгт 4. сая төгрөг

| ТЭЗ | Төсөл, арга хэмжээний нэр | Хугацаа | | Төсвийн тухай хуулиар баталсан | | Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр |
|-----|--|---------|--------|--------------------------------|---------------|---|
| | | Эхлэх | Дуусах | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | |
| ШЕЗ | Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | 2025 | 2026 | 8,043.3 | 3,469.9 | - |

АРА-2026/05-01/ШТА-НА



| | | | | | | |
|-----------------|--|------|------|-----------------|-----------------|--------------|
| ХХААХҮС | 1. Архангай аймгийн бэлчээрт инженерийн хийцтэй 3 худаг шинээр барьж байгуулах ажил | 2025 | 2025 | 94.8 | 94.8 | 3.17.1 |
| ЗТС | Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам, 28.5 км /Хангайн бүс/ | 2025 | 2026 | 43,603.2 | 17,989.4 | 1.3.1. |
| ХББОСС | Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шат /Архангай аймгийн Хотонт, Ихтамир, Чулуут, Өлзийт, Хашаат сум/ | 2025 | 2027 | 5,791.6 | 51.8 | 1.2.2. |
| ЭХС | Багц-1: 1. Сум, суурин газрын цахилгаан хангамж /Архангай, Чулуут сум Зуунмод баг/ 2. Сум, суурин газрын цахилгаан хангамж /Архангай, Өндөр-Улаан сум, Баянгол баг/ Багц-2: 1. Сумын төвийн 0.4 кВ-ын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Архангай, Эрдэнэмандал сум/ | 2025 | 2026 | 2,205.2 | 1,703.8 | 3.8.3, 3.9.6 |
| ЭЗХС | Багц-1: Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын зураг төсөв /Архангай, Эрдэнэбулган сум/ Багц-2: Өндөр-Улаан сумын Хануйн гүүрнээс Эрдэнэмандал сумын төв хүртэлх хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төсөв /Архангай, Өндөр-Улаан сум/ | 2025 | 2025 | 1,279.0 | 1,279.0 | 2.17.4 |
| Нийт дүн | | | | 61,017.1 | 24,588.7 | |

БҮЛЭГ 2. ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ШИНЭ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАЙХГҮЙ ТУЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ БАЙНА

В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжээгүй шинээр хэрэгжсэн 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг орон нутагт үзэх боломжгүй байна

Архангай аймагт 2025 онд эрх шилжээгүй шинээр хэрэгжсэн 5-н Сайд болон ШЕЗ-өөс хэрэгжүүлсэн 61,017.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл аймагт байхгүй байна.

БҮЛЭГ 3. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН 40.9 ХУВИЙГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭС ШАЛТГААЛАН БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН, ХЭРЭГЖИЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 16.6 ХУВЬ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

В.1. Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг гэрээний дагуу хугацаанд нь гүйцэтгүүлэх, санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан олгох шаардлагатай байна

В.1.1. Аймгийн хэмжээнд 2025 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн ТАХ-ний 83.7 хувь нь хугацаандаа хэрэгжсэн байна

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 192,672.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 20 ТАХ-ний 95 хувь буюу 19 барилга байгууламж, 5 хувь буюу 1 тоног төхөөрөмж эзэлж байна.

Тайлант онд эрх шилжин хэрэгжсэн 20 ТАХ-ээс гэрээний хугацаагаар он дамжин хэрэгжих 10 ТАХ, тухайн онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 10 ТАХ байна.



Үүнээс 8 ТАХ-г төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж ашиглалтад оруулсан бол үлдэх 2 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжээгүй буюу төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 80 хувьтай байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ний ангилал, гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний тоо, гэрээний дүн

Хүснэгт 5. /сая.төгрөг/

| Харьяа Сайд | Хэрэгжсэн ТАХ | | Үүнээс | | | | Гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй | |
|-------------------------|------------------|-----------|--------------------|-----------|-----------------|----------|---------------------------------------|----------|
| | | | Барилга байгууламж | | Тоног төхөөрөмж | | | |
| | Гэрээний дүн | ТАХ | Гэрээний дүн | ТАХ | Гэрээний дүн | ТАХ | Гэрээний дүн | ТАХ |
| ЗТХСайд | 117,117.9 | 5 | 117,117.9 | 5 | | | 2,547.6 | 1 |
| Боловсролын Сайд | 35,856.0 | 9 | 35,856.0 | 9 | | | | |
| ХХААХҮС | - | - | | | | | | |
| ГБХНХС | - | - | | | | | | |
| ХББОСС | 26,964.8 | 1 | 26,964.8 | 1 | | | | |
| ЭХСайд | - | - | | | | | | |
| ССАЖЗС | 7,849.1 | 3 | 4,975.5 | 2 | 2,873.6 | 1 | | |
| ЗГХЭГ | 4,884.6 | 2 | 4,884.6 | 2 | | | 2,453.8 | 1 |
| Нийт дүн | 192,672.4 | 20 | 189,798.8 | 19 | 2,873.6 | 1 | 5,001.4 | 2 |

Аймгийн Засаг даргад эрх шилжээгүй хэрэгжсэн 113,224.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 17 ТАХ-ний 94.1 хувь буюу 16 барилга байгууламж, 5.9 хувь буюу 1 ТЭЗҮ эзэлж байна. Эрх шилжээгүй нийт 17 ТАХ-ээс гэрээний хугацаагаар он дамжин хэрэгжих 9 ТАХ, тухайн онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 8 ТАХ байна.

Үүнээс 7 ТАХ-г төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж ашиглалтад оруулсан бол үлдэх 1 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжээгүй буюу төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 87.5 хувьтай байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжээгүй хэрэгжсэн ТАХ-ний ангилал, гэрээний хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний тоо, гэрээний дүн

Хүснэгт 6. сая.төгрөг

| Харьяа байгууллага | Хэрэгжсэн ТАХ | | Үүнээс | | | | Гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй | |
|-------------------------|------------------|-------------|--------------------|-------------|----------------|-------------|---------------------------------------|-------------|
| | | | Барилга байгууламж | | ТЭЗҮ | | | |
| | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо |
| ЗТХСайд | 68,659.2 | 3 | 68,659.2 | 3 | | | | |
| Боловсролын Сайд | 10,694.1 | 4 | 10,694.1 | 4 | | | 1,551.3 | 1 |
| ХХААХҮС | 94.8 | 1 | 94.8 | 1 | | | | |
| ЦХИХХС | 399.4 | 1 | 399.4 | 1 | | | | |
| ХББОСС | 14,399.8 | 2 | 14,399.8 | 2 | | | | |
| БОУАӨС | 1,795.4 | 1 | 1,795.4 | 1 | | | | |
| ССАЖЗС | 4,226.8 | 1 | 4,226.8 | 1 | | | | |
| ЭЗХС | 1,279.0 | 1 | | | 1,279.0 | 1 | | |
| ШЕЗ | 8,043.2 | 1 | 8,043.2 | 1 | | | | |
| ЭХС | 3,633.1 | 2 | 3,633.1 | 2 | | | | |
| Нийт дүн | 113,224.8 | 17 | 111,945.8 | 16 | 1,279.0 | 1 | 1,551.3 | 1 |

Тайлбар: Төсвийн тухай хууль болон гэрээний хугацаанд хэрэгжээгүй 3 ТАХ-ний дэлгэрэнгүй мэдээллийг В.1.4-т дэлгэрэнгүй тусгасан тул танилцана уу.

**В.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн санхүүжилтийн 40.9 хувийг зарцуулаагүй байна**

Аймгийн Засаг даргад 2025 онд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих эрх шилжүүлсэн 20 ТАХ-нд 38,536.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас, гүйцэтгэлээр 18 төсөл, арга хэмжээний 25,835.4 сая төгрөгийн санхүүжилт ирж, гүйцэтгэгч нарт 24,045.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,790.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ. Олгохоор төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл 62.4 хувьтай байна.

Аймагт эрх шилжүүлсэн ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа
Хүснэгт 7. /сая.төгрөг/

| ТЕЗ | Эрх шилжүүлсэн | | Санхүүжилт хийгдсэн | | Зөрүү | | Төлөвлөсөн санхүүжилтийн хувь |
|-------------------------|----------------|-----------------|---------------------|-------------------|-------------|-------------------|-------------------------------|
| | ТАХ-ний тоо | Санхүүжих дүн | ТАХ-ний тоо | Санхүүжилтийн дүн | ТАХ-ний тоо | Санхүүжилтийн дүн | |
| ЗТХСайд | 5 | 15,362.6 | 4 | 7,340.7 | 1 | 8,021.9 | 47.8 |
| Боловсролын Сайд | 9 | 12,453.0 | 9 | 11,885.9 | - | 567.1 | 95.4 |
| ХБООСС | 1 | 5,118.6 | - | - | 1 | 5,118.6 | - |
| ССАЖЗС | 3 | 3,171.9 | 3 | 2,720.5 | - | 451.4 | 85.8 |
| ЗГХЭГ | 2 | 2,430.7 | 2 | 2,098.1 | - | 332.6 | 86.3 |
| Нийт | 20 | 38,536.8 | 18 | 24,045.2 | 2 | 14,491.6 | 62.4 |

ЗТС-аас 2022 онд эрх шилжүүлсэн "Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто зам, /Архангай, Ихтамир, Чулуут сум/" замын байгууламжийн ажилд 2025 онд 6,000.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна. Аймгийн Засаг даргын 2025.12.08-ны өдрийн 01/1650 дугаар албан бичгээр Сангийн яаманд уг төслийн дундын санхүүжилт болох 4,794.7 сая төгрөгийг ЗТСайдын орон нутаг дахь дансанд шилжүүлэх хүсэлтийг хүргүүлсэн боловч тухайн онд санхүүжилтийг шилжүүлээгүй байна. /эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2026.05.01-ны өдрийн 01/646 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарыг үндэслэв/

Аудитын илрүүлэлт:

✓ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдаас 2022 онд эрх шилжүүлсэн "Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц"-ийн ажилд 2025 онд 5,118.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор улсын төсвөөр баталсан хэдий ч ажлын гүйцэтгэл гараагүйгээс төсвийг буцаан татсан байна.

Шийдвэрлэлт: Тухайн жилийн улсын төсвөөр баталсан хөрөнгө оруулалтын ажлыг үр дүнтэй гүйцэтгүүлж санхүүжилтийг бүрэн авах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн Засаг даргад эрх шилжээгүй шинээр болон өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 17 ТАХ-нд 2025 онд 43,660.4 сая төгрөг санхүүжилт олгохоор батлагдсанаас 16 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтэд 24,741.7 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Олгохоор төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл 56.7 хувьтай байна.

Аймагт эрх шилжээгүй ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа
Хүснэгт 8. сая.төгрөг

| ТЕЗ | Эрх шилжээгүй | | Санхүүжилт хийгдсэн | | Зөрүү | | Төлөвлөсөн санхүүжилтийн хувь |
|----------------|---------------|---------------|---------------------|-------------------|-------------|-------------------|-------------------------------|
| | ТАХ-ний тоо | Санхүүжих дүн | ТАХ-ний тоо | Санхүүжилтийн дүн | ТАХ-ний тоо | Санхүүжилтийн дүн | |
| ЗТХСайд | 3 | 27,995.5 | 3 | 10,902.6 | - | 17,092.9 | 38.9 |



| | | | | | | | |
|------------------|-----------|-----------------|-----------|-----------------|----------|-----------------|-------------|
| Боловсролын Сайд | 4 | 2,951.7 | 4 | 2,398.2 | - | 553.5 | 81.2 |
| ХББОСС | 2 | 2,740.9 | 1 | 2,673.1 | 1 | 67.8 | 97.5 |
| ССАЖЗС | 1 | 1,000.0 | 1 | 1,000.0 | - | - | 100.0 |
| БОУАӨС | 1 | 1,398.4 | 1 | 1,398.4 | - | - | 100.0 |
| ЭЗХС | 1 | 1,279.0 | 1 | 866.0 | - | 413.0 | 67.7 |
| ХХААХҮС | 1 | 94.8 | 1 | 94.8 | - | - | 100.0 |
| ЦХИХХС | 1 | 399.4 | 1 | 196.7 | - | 202.7 | 49.2 |
| ШЕЗ | 1 | 3,469.9 | 1 | 2,922.6 | - | 547.3 | 84.2 |
| ЭХС | 2 | 2,330.8 | 2 | 2,289.3 | - | 41.5 | 98.2 |
| Нийт | 17 | 43,660.4 | 16 | 24,741.7 | 1 | 18,918.6 | 56.7 |

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 82,197.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 37 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 34 ТАХ-нд 40.9 хувь буюу 48,565.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, үлдэгдэл **31,841.7** сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь хөрөнгө оруулалтаас иргэд, олон нийтийн хүртэх үр өгөөж, боломжийг алдсан байна.

Барилга угсралт, замын байгууламжийн гүйцэтгэгчдээс бодит ажлын гүйцэтгэл гараагүйгээс шалтгаалан санхүүжилтийг буцаан төвлөрүүлжээ. Төсөл, арга хэмжээ тус бүрээр санхүүжилтийн зөрүүг гаргаж дэлгэрэнгүй байдлаар оруулав. */Тайлангийн хавсралт 1-т дэлгэрэнгүй тусгасантай танилцана уу/*

Дүрслэл 1. Нийт олгосон санхүүжилтийн хуваарилалт

Тайлант онд улсын төсвөөс аймагт олгосон нийт **25,835.4** сая төгрөгийн санхүүжилтийн 91.9 хувь буюу 23,757.4 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 0.8 хувь буюу 215.7 сая төгрөгийг зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд, 0.3 хувь буюу 72.3 сая төгрөгийг техник хяналтын зардалд, 6.9 хувь буюу 1,790.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. */Хэрэгжсэн ТАХ-ний жагсаалтыг тайлангийн хавсралт №2-тай дэлгэрэнгүй танилцана уу/*



Аймагт эрх шилжин 2024 оноос хэрэгжсэн 30,563.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 10 барилга байгууламжийн ажлын төсөв нь гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны дараа төсөв нь магадлалаар хянагдсан мөн барилгын материалын үнийн зөрүүгээр нийт 11,503.5 сая төгрөгөөр нэмэгджээ. Магадлалаар хянагдсан төсвийн хэмжээгээр улсын төсөвт хүндрэл үүсэхээр байна.

Аймагт эрх шилжсэн ТАХ-ний гэрээний дүн болон магадлалаар өссөн төсөвтэй харьцуулсан судалгаа

Хүснэгт 9. сая төгрөг

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Гэрээний дүн | МЕД-ийн огноо дугаар | Хянагдсан төсөв | Зөрүү | Магадлалаар төсөвт өртөг өссөн шалтгаан тайлбар, үндэслэл |
|---|--|--------------|----------------------|-----------------|----------|---|
| 1 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/ | 3,199.7 | 2024/06/21 1097/2024 | 4,100.18 | 900.51 | |
| 2 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өгийнуур сум/ | 3,312.6 | 2024/06/26 984/2024 | 4,802.08 | 1,489.46 | |
| 3 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хашаат сум/ | 3,944.0 | 2024/06/25 963/2024 | 4,840.47 | 896.47 | |

АРА-2026/05-01/ШТА-НА



| | | | | | | |
|-----------------|--|------------------|-------------------------|------------------|------------------|---|
| 4 | Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | 2,810.4 | 2024.06.25 0962/2024 | 4,133.48 | 1,323.09 | Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны дараа зураг төсөв магадлалаар хянагдсан. |
| 5 | Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/ | 3,484.0 | 0962/2024 | 4,133.48 | 649.48 | |
| 6 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг/ | 3,953.0 | 2149/2022 | 4,246.87 | 293.84 | |
| 7 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/ | 2,453.8 | 2024/06/06 0808/2024 | 3,347.85 | 894.01 | |
| 8 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/ | 2,430.7 | 06/06/2024 802/2024 | 3,046.25 | 615.53 | Материалын үнийн зөрүү |
| 9 | Нийтийн биеийн тамирын төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 1, 2, 3, 5, 7 дугаар баг/ | 3,874.5 | 2025/05/20 725/2025 | 6,984.78 | 3,110.28 | |
| 10 | Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/ | 1,101.0 | 2025/05/20 724/2025 | 2,431.89 | 1,330.90 | |
| Нийт дүн | | 30,563.77 | - | 42,067.32 | 11,503.56 | |

В.1.3. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн 37 ТАХ-г ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн байна

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд хэрэгжсэн эрх шилжсэн, шилжээгүй нийт 305,897.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 37 төсөл, арга хэмжээний 98.6 хувь буюу 301,744.6 сая төгрөгийн 35 барилга байгууламж, 0.09 хувь буюу 2,873.6 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмж, 0.004 хувь буюу 1,279.0 сая төгрөгийн 1 ТЭЗҮ-ийн ажлууд байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн эрх шилжсэн, шилжээгүй ТАХ-ний мэдээлэл, ангиллаар

Хүснэгт 10. сая төгрөг

| Эрх шилжсэн байдал | Нийт ТАХ | | Барилга байгууламж | | Тоног төхөөрөмж | | ТЭЗҮ | |
|----------------------|-----------|------------------|--------------------|------------------|-----------------|----------------|----------|----------------|
| | ТАХ | Гэрээний дүн | ТАХ | Гэрээний дүн | ТАХ | Гэрээний дүн | ТАХ | Гэрээний дүн |
| Эрх шилжсэн | 20 | 192,672.4 | 19 | 189,798.8 | 1 | 2,873.6 | - | - |
| Эрх шилжээгүй | 17 | 113,224.8 | 16 | 111,945.8 | - | - | 1 | 1,279.0 |
| Нийт | 37 | 305,897.2 | 35 | 301,744.6 | 1 | 2,873.6 | 1 | 1,279.0 |

Тайлант онд хэрэгжсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлжээ.

В.1.4. Аймгийн хэмжээнд 2025 онд хэрэгжиж дуусгахаар төлөвлөсөн нийт 18 ТАХ-ний 16.6 хувь нь хугацаандаа хэрэгжээгүй, гэрээ дүгнээгүй байна

Төсвийн тухай хууль болон гэрээний хугацаагаар 2025 онд дуусгахаар төлөвлөсөн эрх шилжсэн 10, эрх шилжээгүй 8, нийт 18 төсөл арга хэмжээнээс гэрээний хугацаанд хэрэгжсэн 16, үлдэх 2 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан он дамжжээ. Гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалан төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удааширч байгаа нь өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Боловсролын Сайдаас эрх шилжээгүй өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг 50 ортой барилга"-ын ажлын гүйцэтгэгч "Зол билэг" ХХК нь 1,551.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй ажлыг 2024.10.24-2025.12.31-ны



хооронд гүйцэтгэхээр гэрээг байгуулсан боловч гэрээний хугацаа болон Төсвийн тухай хуулиар баталсан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй.

- ✓ ЗТС-аас 2024 онд эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Цахир сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5км замын байгууламжийн ажлын гүйцэтгэгч "Эвт-уул" ХХК нь 2,547.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй ажлыг 2024.04.30-2025.12.31-ны хооронд гүйцэтгэхээр гэрээг байгуулсан боловч гэрээний хугацаа болон Төсвийн тухай хуулиар баталсан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.6¹, МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.6², гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 46.1³ дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төсвийн тухай хуулиар баталсан хугацаа болон гэрээний хугацаанд ажлаа хэрэгжүүлээгүй дээрх гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээг дүгнэх арга хэмжээг авах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын БОНХОТХ болон ГХБХБГ-т хүргүүлэв.

В.2. Барилга байгууламжийн зарим материалын шаардлагад хяналт хэрэгжүүлээгүй, комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдаагүй байна

В.2.1. Аймагт эрх шилжин хэрэгжсэн 14 барилга байгууламж, 5 замын байгууламжийн ажилд зохиогчийн болон захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн байна

Аймгийн хэмжээнд эрх шилжин хэрэгжсэн 192,672.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 20 ТАХ-ээс 72,680.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 барилга байгууламж, 2,873.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 тоног төхөөрөмж, 117,117.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 замын байгууламжийн ажлууд хэрэгжжээ.

Аймгийн ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын албанаас 14 барилга байгууламжид тухай бүр захиалагчийн хяналт хийж, захиалагчийн хяналтын явцын дүгнэлт, ил далд ажлын акт, фото зургаар баталгаажуулсан байна.

ЗТС-аас эрх шилжсэн 5 замын байгууламжийн ажилд "Мөнхөд ашдын зам" ХХК - 2 ТАХ-нд "Танил санаа" ХХК -1 ТАХ-нд, "Жи Ар Си" ХХК -1 ТАХ-нд, "Арвай нутгийн зам" ХХК -1 ТАХ-нд зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж, зөвлөх үйлчилгээний тайлан, дүгнэлт, ил далд ажлын акт, үйлдэж баталгаажуулан фото зургаар баримтжуулжээ.

В.2.2. Барилга угсралтын бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандартад хяналт хэрэгжүүлж байгаа хэдий ч заслын ажлын материалын шаардлагад дүгнэлт гаргах боломжгүй байна

Аймгийн ГХБХБГ-ын дэргэдэх барилгын материалын лаборатори нь 2024 онд 11 нэр төрлийн 312 дээжид, 2025 онд 9 нэр төрлийн 466 дээжид сорил шинжилгээ хийж, орон нутгийн төсөвт 25.7 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

¹ "Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавих.."

² "Захиалагч ... гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, ... гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана"

³ "Гүйцэтгэгч ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутам гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө"



Аймгийн хэмжээнд улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн 14, 5 Сайдын багцаас эрх шилжээгүй хэрэгжүүлсэн 9, нийт 23 барилга угсралтын ажлын төсөл, арга хэмжээнд барилгын материалын лабораториор бетоны сорьц, бетоны орц найрлага, тоосго, хөөсөнцөр, хүрмэн гулдмай, явган замын талбайн хавтан, бродюр зэрэгт сорилт шинжилгээ хийж дүгнэлт гаргаж байгаа хэдий ч

химийн, хуванцар хаалга, цонх, металл эдлэхүүн, будгийн хэмжилт хийх тоног төхөөрөмжийн байхгүй байгаагаас шалтгаалан дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Үүнээс шалтгаалан барилгын гадна болон дотор заслын ажилд ашигласан эмульс, будаг, хуванцар хаалга, цонх нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй эсэх, мөн зураг төсвийн дагуу хийгдсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга байгууламжийн материалын чанарт тавих хяналтыг сайжруулах чиглэлээр лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах зөвлөмжийн аймгийн Засаг даргад хүргүүлэв.

В.2.3. Аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд ТАХ-ний хэрэгжилтэд комисс заавар, журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна

Аймгийн хэмжээнд эрх шилжсэн болон эрх шилжүүлээгүй хэрэгжсэн нийт 37 ТАХ-ээс тайлант онд гэрээний хугацаагаар дуусгаж хүлээлгэн өгөх 18 ТАХ-ээс 15 ТАХ-г улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан, харин 3 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжжээ.

Улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан 15 ТАХ-ний гүйцэтгэлийг газар дээр нь тулган шалгаж комиссоос үүрэг даалгаврын биелэлтийг тулган шалгаж фото зургаар баримтжуулав.

Аудитын илрүүлэлт:

- ✓ ЗТХЯ-аас 2019 оноос эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжсэн “Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК нь 2019.12.19-2025.08.31-ны хооронд хийж гүйцэтгэхээр 71,070.5 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулж 2025 оны байдлаар нийт 70,958.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/319 дугаар захирамжийн дагуу үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авчээ.

Замын байгууламжийн ашиглалт, улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг газар дээр нь очиж тулган шалгахад Ястын 1 дүгээр карьер 3 хэсэг талбай 3 га, Ухаагийн 2 дугаар карьер 2 га, Тооромтын өвөрт 3 дугаар карьер 2 га, Өндөр-Улааны үүр 4 дүгээр карьер /хайрга/ 0.5 га, Улаан толгой 5 дугаар карьер 5 га үүнээс ашигласан талбай 2 га нийт 9.5 га чулуун ба шороон ордуудыг дарж хэлбэршүүлэх нөхөн сэргээлтийн ажлыг



АРА-2026/05-01/ШТА-НА



гүйцэтгээгүй, замын далан ба ухмалын хажуу талын 45 градусын налуутай тэгшлэх ажлууд нь хүйтний улиралтай холбоотой хийгдээгүй, зам ашиглалтын явцад хажуу талын 10 ш түмбэ хугарч унасан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14.6, 14.7 дахь хэсэг, МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.9.2⁴-д заасан байна.

Шийдвэрлэлт: Замын байгууламжийг гүйцэтгэгч "Хурдны зам" ХХК-р улсын комиссоос өгсөн нөхөн сэргээлтийн ажлын үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, ашиглалтын явцад эвдэрсэн 10 ш түмбийг шинээр солих арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн БОНХОТХ-т албан шаардлага хүргүүлэв.

В.2.4. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний 94.3 хувь нь мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан байна

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн 37 ТАХ-ээс барилга угсралт 23, замын байгууламж 7, инженерийн дэд бүтэц 1, эрчим хүчний дэд бүтэц 2, ногоон байгууламж 2, тоног төхөөрөмж 1, ТЭЗҮ 1 байна. Тоног төхөөрөмж, ТЭЗҮ-ээс бусад ажлуудад мэдээллийн самбар байршуулахаас 94.3 хувь нь хуулийн дагуу мэдээлсэн байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн ТАХ-ний ангилал

Хүснэгт 11.

| Эрх шилжсэн байдал | Нийт ТАХ | Барилга угсралт | Замын байгууламж | Инженерийн дэд бүтэц | Эрчим хүчний дэд бүтэц | Ногоон байгууламж | Тоног төхөөрөмж | ТЭЗҮ |
|--------------------|-----------|-----------------|------------------|----------------------|------------------------|-------------------|-----------------|----------|
| Эрх шилжсэн | 20 | 14 | 5 | - | - | - | 1 | - |
| Эрх шилжээгүй | 17 | 9 | 2 | 1 | 2 | 2 | - | 1 |
| Нийт | 37 | 23 | 7 | 1 | 2 | 2 | 1 | 1 |

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.10, 8.6.11 дэх заалт, Монгол Улсын үндэсний стандарт /MNS 7023:2023/-ын дагуу мэдээллийн самбар байршуулсан эсэхийг газар дээр нь очиж тулган шалгахад барилга угсралтын 2 ажлын гүйцэтгэгч нь байршуулаагүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Боловсролын Сайдаас эрх шилжээгүй өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг 50 ортой барилга",
- ✓ Аймагт эрх шилжсэн өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Хайрхан сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга"-ын ажлын гүйцэтгэгчид нь барилга байгууламжийн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байршуулаагүй байна.

Шийдвэрлэлт: Барилга угсралтын гүйцэтгэгч нараар стандартын дагуу мэдээллийн самбарыг байршуулах, түүнд хяналт тавьж ажиллах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

⁴ "... барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна ..."

**В.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж, ашиглалтад хүлээн авсан хөрөнгийн 80 хувийг бүрэн хүчин чадлаар зориулалтын дагуу ашиглаж байна**

В.3.1 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн 33.3 хувийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, 80 хувийг хүчин чадал зориулалтын дагуу ашиглаж байна

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 37 төсөл, арга хэмжээнээс он дамжин хэрэгжиж байгаа 17 ТАХ, хугацаандаа хэрэгжээгүй 4 ТАХ, огт хэрэгжээгүй 1 ТАХ, гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж дууссан 15 ТАХ байна.

Аймгийн хэмжээнд УТХО-аар хэрэгжсэн эрх шилжсэн 7 ТАХ, эрх шилжээгүй 8 ТАХ нь хугацаандаа болон гэрээний хугацаанаас өмнө хийгдэж хүлээлгэн өгсөн байна.

Ашиглалтад хүлээн авсан ТАХ-ний хүчин чадал, нягтлан бодох бүртгэл

Хүснэгт 12. сая төгрөг

| № | Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр | Төсөл, арга хэмжээний нэр | Гэрээний үнэ | Хүчин чадал | Зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх | Ашиглагчийн | | Тайлбар |
|---------------------------------|------------------------------------|--|-----------------|--|---------------------------------------|----------------------------|------------------------------|--|
| | | | | | | Нэр | Бүртгэлд тусгасан мөнгөн дүн | |
| 1 | Зам, тээврийн сайд | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ | 71,070.5 | 63 км | Тийм | | | ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй. |
| 2 | МУСЗГХЭГ-ын дарга | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/ | 2,430.8 | 756 | Тийм | | | ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй. |
| 3 | Боловсролын сайд | Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/ | 3,484.0 | 160 суудал | Тийм | ЭБ сумын 3 дугаар сургууль | 3,484.00 | |
| 4 | Боловсролын сайд | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/ | 3,162.4 | 150 ор | Тийм | ЭБ сумын 3 дугаар цэцэрлэг | 3,162.38 | |
| 5 | Зам, тээврийн сайд | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Булган сум/ | 2,551.2 | 1.5 км | Тийм | | | ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй. |
| 6 | Зам, тээврийн сайд | Сумын төвийн доторх 1.5 км хатуу хучилттай авто зам /Архангай, Хайрхан сум/ | 1,496.0 | 1.5 км | Тийм | | | ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй. |
| 7 | ССАЖЗСАйд | Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/ | 2,873.7 | 0 | Үгүй | Архангай аймгийн ХДТеатр | 2,873.63 | 0 |
| Эрх шилжсэн ТАХ нийт дүн | | | 87,068.6 | 85.7 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна | 42.8 хувь НББ бүртгэсэн | | - | |
| 1 | Боловсролын сайд | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | 2,480.09 | 150 ор | Тийм | Төвшрүүлэх сумын ЕБС | 2,480.09 | |
| 2 | БОУАӨСайд | Өгий нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Архангай/ | 1,749.17 | | Тийм | | | |
| 3 | ХХӨӨХҮСАйд | Бэлчээрийн усан хангамж /Бүсүүд/ | 94.79 | | Тийм | Өгийнуур сумын ЗДТГ | 31.60 | Өндөр-улаан, Хайрхан сум НББ бүртгээгүй байна. |
| 4 | ХББОССайд | Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Архангай, Их тамир/ | 8,608.2 | | Үгүй | | | ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй. |



| | | | | | | | |
|-----------------------------------|---------------------------------|---|-------------------|--------|--|--------------------------------|---|
| 5 | Эрчим хүчний сайд | Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Эрдэнэмандал дэд бүтэц/ | 1,211.3 | | Үгүй | | |
| 6 | Эрчим хүчний сайд | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Архангай, Эрдэнэбулган сум/ | 1,428.0 | 25 мВа | Тийм | | ЭХСайдад хөрөнгөд бүртгэл хүсэлт хүргүүлсэн |
| 7 | ЦХИХХСайд | Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Чулуут, Өндөр-Улаан/ | 399.4 | | Тийм | | |
| 8 | МУТШСайд д бөгөөд ЭЗХСайд | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ | 1,279.0 | | Тийм | | |
| Эрх шилжээгүй ТАХ нийт дүн | | | 15,571.5 | | 75 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна | 25 хувь НББ бүртгэсэн | - |
| Нийт ТАХ-ны дүн | | | 102,640.15 | | 80 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна | 33.3 хувь НББ бүртгэсэн | |

Ашиглалтад хүлээн авсан 15 ТАХ-аас 80 хувь буюу 12 ТАХ-г зориулалтын дагуу хүчин чадлаар нь ашиглаж, 33.3 хувь буюу 5 ТАХ-г санхүүгийн тайланд бүртгэн тайлагнасан байна.

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 100,279.8 сая төгрөгийн 13 ТАХ-г ашиглагч байгууллага бүрэн хүчин чадал зориулалтын дагуу ашиглаж байна. Тухайлбал.

Сайн жишээ:

Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан боловсролын салбарын 160 хүүхдийн суудалтай 1 ЕБС-ийн барилга, 300 ортой 1 хүүхдийн цэцэрлэгийг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

1. Төвшрүүлэх сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн суралцах, хүмүүжих орчин сайжирч, улсын хэмжээнд тэргүүний жишиг цэцэрлэг болсон бөгөөд энэ нь боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжид эерэг нөлөө үзүүлсэн байна.

Дүрслэл 2.



2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын багцаас хэрэгжсэн Ихтамир сумын инженерийн дэд бүтэц, хангамж төслийн гүйцэтгэгчтэй 8,608.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн



А/610 дугаар захирамжийн дагуу улсын комиссын 2025.11.05-ны өдрийн №ББАОҚД-2025/45 дугаар актаар байнгын ашиглалтад хүлээн авчээ. Ихтамир сумын хэмжээнд нэгдсэн халаалт, цэвэр, бохирын шугамын дэд бүтэцэд орон нутгийн төсөвт 5, хувийн аж ахуйн нэгж 6, айл өрх 15 нийт 26 хэрэглэгч холбогдсон байна. Цаашид сумын төвийн 38 өрх нэгдсэн шугам сүлжээнд холбогдох боломжтой болсон нь сумын иргэд ая тухтай орчинд амьдрах, ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн үр дүнтэй төсөл, арга хэмжээ болжээ.

Дүрслэл 3.



**СУМЫН ХӨГЖИЛ,
ИНЖЕНЕРИЙН ДЭД
БҮТЦИЙН ХАНГАМЖ**



Харин Соёлын Сайдын багцаас эрх шилжин хэрэгжсэн “Аймгийн Хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж”-ын ажлын гүйцэтгэгчтэй 2,873.6 сая төгрөгийн гэрээг байгуулж, улсын комиссын 2024.12.17-ны өдрийн актаар байнгын ашиглалтад 2,848.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 25.4 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч бүртгэлд тусгасан боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2012 оноос хойш хэрэгжиж буй “Хөгжимт драмын театр”-ын шинэ барилга ашиглалтад ороогүйтэй холбоотойгоор уг тоног төхөөрөмжийг ашиглаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын багцаас шинээр хэрэгжсэн 900.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй "Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах /Архангай, Эрдэнэмандал/ төсөл хэрэгжиж 2025 оны 12 дугаар сард улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Ашиглалтын байдлыг газар дээр нь очиж тулгахад орон сууцанд 1 төрийн албан хаагчид түрээсийн гэрээгээр (сумын ЭМТ-ийн шүдний эмч) ашиглуулж байгаа хэдий ч 7 орон сууц түрээслэгчгүй буюу ашиглалтгүй байна.

Эрдэнэмандал суманд хэрэгжсэн Төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц

Дүрслэл 4.



АРА-2026/05-01/ШТА-НА



Шийдвэрлэлт: Төрийн албан хаагчийн орон сууцны ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:


Эрчим хүчний сайдын багцаас санхүүжсэн 1,211.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн 0.4 кВ-ын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Архангай аймаг, Эрдэнэмандал сум/” ажлыг гүйцэтгэгч “Иннермост” ХХК-тай 1,211.3 сая төгрөгийн гэрээ байгуулан хэрэгжүүлж, 2025 оны 11 дүгээр сард улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Гүйцэтгэлээр 21.7 км урттай шугам сүлжээ баригдаж, засварын 299, тулаастай 326 (163 хос) нийт 625 ширхэг бетонон тулгуур суурилуулан 0.4 кВ-ын шугамаар холбож хүчитгэл хийсэн байна.

Гэсэн хэдий ч 2026 оны 04 дүгээр сарын байдлаар тус шугам сүлжээнд 7 төсөвт байгууллага, 741 айл өрхийг холбох ажил хийгдээгүй, ашиглалтад бүрэн ороогүй, хөрөнгө оруулалтын үр ашиг хангагдаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.1⁵ дэх заалттай нийцэхгүй байна.

Эрдэнэмандал суманд хэрэгжсэн 0.4 кВ-ын шугамын трассын зураг

Дүрслэл 5.



Шийдвэрлэлт: Цахилгаан дамжуулах шугамыг төсөвт байгууллага болон айл, өрхүүдэд шилжүүлж, үр ашгийг дээшлүүлэх саналыг ҮАГ-аар дамжуулан ЭХЯ-нд уламжилж байна

Тайлант онд бүрэн хэрэгжсэн 15 ТАХ-ээс ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу 4 ТАХ-ийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн, 10 ТАХ-г орон нутгийн өмчид бүртгүүлэх хүсэлтийг салбар яамдад албан бичгээр хүсэлтийг хүргүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

⁵ Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас хэрэгжсэн 94.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бэлчээрийн усан хангамж” ТАХ-ны хүрээнд баригдсан худгийг Хайрхан, Өндөр-Улаан сумын ЗДТГ нь тухайн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1, 4.1.4, 4.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан 2 худгийг нягтлан бодох бүртгэлд тусгуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг ОНӨГ-т хүргүүлэв

В.3.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг батлагдсан шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцож, үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнаж үнэлүүлсэн байна

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт”, “Архангай аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт” үр дүнг холбогдох шалгуур үзүүлэлтэд үндэслэн үнэлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэгтгэн тайлагнажээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/44 дүгээр тогтоолоор аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

В.3.3 Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 77 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 36 ТАХ-ны гүйцэтгэлээс 15 ТАХ бүрэн хэрэгжсэн 100 хувь, гэрээгээр он дамжсан 10 ТАХ 80–99 хувь, 4 ТАХ 60–79 хувь, 7 ТАХ 10–59 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт ажлын гүйцэтгэлийн дундаж 77 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 13

| № | Төсөл арга хэмжээний тоо | Ажлын гүйцэтгэлийн хувь | Гүйцэтгэлийн дундаж хувь |
|---|--------------------------|-------------------------|--------------------------|
| 1 | 15 | 100 | 77 |
| 2 | 10 | 99-80 | |
| 3 | 4 | 79-60 | |
| 4 | 7 | 59-10 | |

Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан боловсролын салбарын 3 барилга байгууламж, зам тээврийн салбарын 3 байгууламжийн ашиглалт хэвийн бөгөөд төлөвлөсөн зорилт, үр дүнд бүрэн хүрсэн байна.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний хүчин чадал, ашиглалт

Хүснэгт 14

| Салбар | Хуулийн код | Төсөл арга хэмжээний нэр | Хэрэгжсэн ТАХ-ний хүчин чадал | Одоогийн хүчин чадал | Хувь |
|-----------|-------------|--|-------------------------------|----------------------|------|
| Боловсрол | XII.1.1.48 | Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/ | 160 суудал | 160 суудал | 100% |



| | | | | | |
|--------------------|-------------|--|--------|--------|------|
| | XII.1.1.78 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/ | 150 ор | 150 ор | 100% |
| | XII.1.1.149 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | 150 ор | 150 ор | 100% |
| Зам, тээврийн сайд | XIV.1.1.86 | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ | 63 км | 63 км | 100% |
| | XIV.1.1.40 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Булган сум/ | 1.5 км | 1.5 км | 100% |
| | XIV.1.1.37 | Сумын төвийн доторх 1.5 км хатуу хучилттай авто зам /Архангай, Хайрхан сум/ | 1.5 км | 1.5 км | 100% |

Аймгийн Засаг даргад 2025 онд эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжих 20 төсөл, арга хэмжээнээс гэрээгээр он дамжин хэрэгжих 13 ТАХ-ний бодит гүйцэтгэлийг аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан дэвшүүлсэн зорилтот түвшинтэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд дэвшүүлсэн зорилтоос ажлын бодит гүйцэтгэл 9.8 хувиар буурчээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн ТАХ-ний зорилтот түвшин, бодит ажлын гүйцэтгэл

Хүснэгт 15.

| № | Хуулийн код | Төсөл, арга хэмжээний нэр | Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтот түвшин | Аудитаарх 2025 оны бодит ажлын гүйцэтгэл /хувиар/ |
|-----------------|-------------|---|--|---|
| 1 | XIV.1.1.82 | Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 65.8 км /Архангай, Ихтамир, Чулуут сум/ | 0.00 | 80% |
| 2 | XII.1.1.9 | Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | 100% | 87% |
| 3 | XII.1.1.70 | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 5 дугаар цэцэрлэг/ | 75% | 75% |
| 4 | XII.1.1.81 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өгийннуур сум/ | 75% | 70% |
| 5 | XII.1.1.82 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/ | 75% | 65% |
| 6 | XII.1.1.77 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 14 дүгээр цэцэрлэг/ | 75% | 70% |
| 7 | XII.1.1.76 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хашаат сум/ | 75% | 80% |
| 8 | XII.1.1.80 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг/ | 75% | 85% |
| 9 | XV.2.1.4 | Нийтийн биеийн тамирын төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 1, 2, 3, 5, 7 дугаар баг/ | 75% | 35% |
| 10 | XV.2.1.6 | Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/ | 100% | 60% |
| 11 | XVI.1.35 | Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ | 0.00 | 30% |
| 12 | VI.1.2 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/ | 0.00 | 57% |
| 13 | XIV.1.1.41 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Цахир сум/ | 40% | 80% |
| НИЙТ ДҮН | | | 77% | 67.2% |

В.3.4 Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 90 хувьтай байна



Өмнөх аудитаар нийт 26,589.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 5,465.4 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 698.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилт 88.3 хувьтай, 20,424.9 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, бүрэн хэрэгжжээ. Шийдвэрийн хэрэгжилт дунджаар 90 хувьтай байна.

Дүрслэл 6. Өмнөх аудитаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилт



Аудитаар улсын комиссын актаар хүлээн авсан **20,424.9** сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй **7** барилга байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээ аваагүй зөрчил илэрсэнд аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн зөвлөмж бүрэн хэрэгжиж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусган өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сайжирсан байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Архангай аймгийн хэмжээнд улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах 41 саналыг хүргүүлсэн байна
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 6 төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна
- ✓ Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн санхүүжилтийн 40.9 хувийг гүйцэтгэгчээс шалтгаан буцаан төвлөрүүлсэн, 2025 онд дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 16.6 хувь нь хугацаандаа хэрэгжээгүй байна
- ✓ Аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн 37 ТАХ-г ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн байна
- ✓ Аймагт эрх шилжин хэрэгжсэн 14 барилга байгууламж 5 замын байгууламжийн ажилд зохиогчийн болон захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн байна
- ✓ Барилгын материалын лабораторийн хүчин чадал хангалтгүйгээс барилга байгууламжийн заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжээгүй байна
- ✓ Аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд ТАХ-ний хэрэгжилтэд комисс заавар, журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна
- ✓ Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний 94.3 хувь нь мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан байна
- ✓ Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн 33%ийг бүртгэл тайланд бүртгэж, нийт хөрөнгө оруулалтын 80 хувийг зориулалтын дагуу ашиглаж байна
- ✓ Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг батлагдсан шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцож, бодлогын зорилтын хэрэгжилтийн түвшинд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнаж үнэлүүлсэн байна
- ✓ Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 77 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.
- ✓ Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт дунджаар 90 хувьтай байна

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН 40.9 ХУВИЙГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭС ШАЛТГААЛАН БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН, ХЭРЭГЖИЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 16.6 ХУВЬ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

Аудитын дүн: Аудитаар нийт **5,062.3 сая төгрөгийн** зөрчил илэрсэнд 8 албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга, холбогдох байгууллагуудад, 1 асуудлыг YAГ-т уламжиллаа.

-----oOo-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга байгууламжийн материалын чанарт тавих хяналтыг сайжруулах чиглэлээр лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 06 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2026 оны 12 дугаар сарын 05-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.





ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2026.05.04 № 06/653
танай _____-ны № _____-т

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Манай аймагт 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой тайлбар саналгүй болно.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА А.БАТБОЛД



А. Батболд

Батболд 4/5

652600700612



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/15

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/175 тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд боловсруулж, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Цэрэннадмид)-д үүрэг болгосугай.

4. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д даалгасугай.

5. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



Тэргүүлэх аудит өгнөмтний №... оны ... дугаар сарын ... өдрийн
 2026 05
 ТООТ ТУШААЛЫН ХАВСРАЛТ №1

"Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: ГАГ-2026/05-ШТА-НА

| № | Хүргүүлсэн шийдвэрийн | | | | Хэрэгжилтийг хариуцах | | | |
|---|--|----------------------------|-----|-----------------|-----------------------|--|---------------------|--|
| | Утга | Мөнгөн дүн /сая төгрөгөөр/ | Тоо | Шийдвэр | Дугаар | Байгууллага албан тушаал | Албан тушаалтны нэр | |
| 1 | 1. Боловсролын Сайдаас эрх шилжээгүй өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг 50 ортой барилга"-ын ажлын гүйцэтгэгч "Зол билэг" ХХК нь 1,551.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй ажлыг 2024.10.24-2025.12.31-ны хооронд гүйцэтгэхээр гэрээг байгуулсан боловч гэрээний болон Төсвийн тухай хуулиар баталсан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй. | 1,551.3 | 1 | Албан шаардлага | 352 | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга | Ч.Отгонжаргал | |
| 2 | Зам тээврийн Сайдаас 2024 онд эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Цахир сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5км замын байгууламжийн ажлын гүйцэтгэгч "Эвт-уул" ХХК нь 2,547.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй ажлыг 2024.04.30-2025.12.31-ны хооронд гүйцэтгэхээр гэрээг байгуулсан боловч гэрээний болон Төсвийн тухай хуулиар баталсан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй. | 2,547.6 | 1 | Албан шаардлага | 353 | ЗДТГ-ын бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга | А.Батболд | |
| 3 | Зам тээврийн яамнаас 2019 оноос эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжсэн "Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63км" төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/319 дугаар захирамжийн дагуу үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан боловч Ястын 1 дүгээр карьер 3 хэсэг талбай 3 га, Ухаагийн 2 дугаар карьер 2 га, Тооромтын өвөрт 3 дугаар карьер 2 га, Өндөр-Улааны үүр 4 дүгээр карьер /хайрга/ 0.5 га, Улаан толгой 5 дугаар карьер 5 га үүнээс ашигласан талбай 2га нийт 9.5 га чулуун ба шороон ордуудыг дарж хэлбэршүүлэх нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгээгүй, замын далан ба ухмалын хажуу талын 45 градусын налуутай тэгшлэх ажил хийгдээгүй мөн ашиглалтын явцад замын хажуу талын 10 ш дүмбэ хугарч унасан байна | - | 1 | Албан шаардлага | 354 | ЗДТГ-ын бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга | А.Батболд | |
| 4 | Боловсролын Сайдаас эрх шилжүүлээгүй өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэг 50 ортой барилга" мөн эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжин хэрэгжиж буй "Хайрхан сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга"-ын ажлын гүйцэтгэгчид нь барилга байгууламжийн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байршуулаагүй байна | - | 1 | Албан шаардлага | 355 | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга | Ч.Отгонжаргал | |
| 5 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 1,669.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Өгийнуур сумын 120 хүүхдийн дотуур байр"-ны ажлыг 2025 оны 10 дүгээр сарын 08-ны өдөр улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан хэдий ч дээрээс дусаал гоожсон, ус халаагч бойлуур болон усны нөөцлөгч савны хүчин чадал бага байгаагаас усанд орох өрөөг огт ашиглаагүй байна. | - | 1 | Албан шаардлага | 356 | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга | Ч.Отгонжаргал | |
| 6 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын багцаас хэрэгжүүлсэн "Бэлчээрийн усан хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд баригдсан 63,196.368 төгрөгийн 2 ш худгийг Хайрхан, Өндөр-Улаан сумын ЗДТГ нь нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй. | 63.2 | 1 | Албан шаардлага | 357 | аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга | Х.Ганхуягт | |
| 7 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын багцаас шинээр хэрэгжсэн 900.2 сая төгрөгийн гэрээний мөнгөн дүнтэй "Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах /Архангай, Эрдэнэмандал/ төсөл хэрэгжиж 2025 оны 12 дугаар сард улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Ашиглалтын байдлыг газар дээр нь очиж тулгахад орон сууцанд 1 төрийн албан хаагчид түрээсийн гэрээгээр (сумын ЭМТ-ийн шүдний эмч) ашиглуулж байгаа хэдий ч 7 орон сууц түрээслэгчгүй буюу ашиглалтгүй байна. | 900.2 | 1 | Албан шаардлага | 358 | аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга | Х.Ганхуягт | |
| 8 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдаас 2022 онд эрх шилжүүлсэн "Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц"-ийн ажилд 2025 онд 5,118.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор улсын төсвөөр баталсан хэдий ч ажлын гүйцэтгэл гараагүйгээс төсвийг буцаан татсан байна. | - | 1 | Албан шаардлага | 359 | Архангай аймгийн Засаг дарга | Б.Цэрэннадмид | |



| | | | | | | | |
|----|---|---------|----|----------------|----|------------------------------|---------------|
| 9 | Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар аймагт эрх шилжин хэрэгжсэн 19, ТЭЗ буюу 7 сайдын багцаас эрх шилжээгүй хэрэгжүүлсэн 11, нийт 30 барилга байгууламжийн төсөл, арга хэмжээнд аймгийн ГХБХБГ-ын дэргэдэх барилгын материалын лабораториор бетоны сорьц, орц найрлага, тоосго, хөөсөнцөр, хүрмэн гулдмай, явган замын хавтан, бродюр зэрэгт сорилт шинжилгээ хийж дүгнэлт гаргаж байгаа хэдий ч химийн шинжилгээ, хуванцар хаалга, цонх, металл эдлэл, будгийн чанарын үзүүлэлт тодорхойлох тоног төхөөрөмж дутмаг байгаагаас зарим материалд дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна. | | 1 | Зөвлөмж | 52 | Архангай аймгийн Засаг дарга | Б.Цэрэннадмид |
| 10 | Эрчим хүчний Сайдын багцаас эрх шилжээгүй шинээр хэрэгжсэн 1,211.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн 0.4 кВ-ын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Архангай, Эрдэнэмандал сум/ ажлын гүйцэтгэгч "Иннермост" ХХК-тай 1,211.3 сая төгрөгийн үнэтэй гэрээг байгуулж гүйцэтгүүлж, 2025 оны 11 дүгээр сард улсын комиссоос байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Гүйцэтгэгчээс 2025 онд 21.7 км-ийн урттай засварын тулгуур 299, тулаастай тулгуур 163*2 нийт 625 бетонон шонг суурилуулж 380 шугамаар холбож хүчитэл өгч улсын комиссын актаар ашиглалтад хүлээлгэн өгсөн хэдий ч 2026 оны 04 дүгээр сарын байдлаар 7 төсөвт байгууллага болон 741 айл өрхүүдэд цахилгаан холболт хийгдээгүй, ашиглалтгүй байна. | | 1 | ҮАГ-т уламжлах | | ҮАГ-аар дамжуулан ЭМЯ-нд | |
| | Албан шаардлага | 5,062.3 | 8 | | | | |
| | Уламжлах санал | - | 1 | | | | |
| | Зөвлөмж | - | 1 | | | | |
| | НИЙТ ДҮН | 5,062.3 | 10 | | | | |

**ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ №1**

*Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын батлагдсан санхүүжилт,
гүйцэтгэл, шалтгаан*

/сая төгрөгөөр/

| № | Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр | Батлагдсан санхүүжилт | Олгосон санхүүжилт | Үлдэгдэл | | Санхүүжилт дутуу авсан шалтгаан |
|----|----------------|--|-----------------------|--------------------|-----------------|------------------|--|
| | | | | | Барьцаа дансанд | Буцаан татуулсан | |
| 1 | XIV.1.1.86 | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ | 5,822.3 | 4,389.4 | 1,261.37 | 171.5 | Гүйцэтгэгчээс шалтгаалан ажлын гүйцэтгэл гараагүй. |
| 2 | XIV.1.1.82 | Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 65.8 км /Архангай, Ихтамир, Чулуут сум/ | 6,000.1 | - | | 6,000.1 | Сангийн яамнаас санхүүжилтийг олгоогүй. |
| 3 | XVI.1.35 | Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ | 5,118.6 | - | | 5,118.6 | Гүйцэтгэгчээс шалтгаалан ажлын гүйцэтгэл гараагүй. |
| 4 | VI.1.1 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/ | 1,203.8 | 888.3 | 20.61 | 294.9 | Ашиглалтад хүлээн авсан. Гүйцэтгэлийн баталгаа болон техник хяналтын зардал татагдсан. |
| 5 | VI.1.2 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/ | 1,226.9 | 1,136.9 | 20.64 | 69.3 | |
| 6 | XII.1.1.9 | Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | 1,267.6 | 926.0 | 16.8 | 324.8 | |
| 7 | XII.1.1.48 | Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/ | 1,680.5 | 1,650.0 | 29.7 | 0.8 | |
| 8 | XII.1.1.70 | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 5 дугаар цэцэрлэг/ | 2,487.9 | 2,443.9 | 44.0 | (0.0) | |
| 9 | XII.1.1.81 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өгийнуур сум/ | 1,215.9 | 1,194.4 | 21.5 | 0.0 | |
| 10 | XII.1.1.82 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/ | 1,215.9 | 1,183.7 | 32.2 | 0.0 | |
| 11 | XII.1.1.77 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 14 дүгээр цэцэрлэг/ | 1,002.2 | 984.3 | 17.9 | 0.0 | |
| 12 | XII.1.1.78 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/ | 904.4 | 888.4 | 16.0 | 0.0 | |
| 13 | XII.1.1.76 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хашаат сум/ | 1,486.0 | 1,454.1 | 31.8 | 0.0 | |
| 14 | XII.1.1.80 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг/ | 1,192.6 | 1,161.0 | 31.6 | (0.0) | |





| | | | | | | | |
|--------------------------------|-------------|--|----------|----------|---------|----------|--|
| 15 | XIV.1.1.40 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Булган сум/ | 1,273.9 | 1,180.1 | 73.93 | 19.9 | Ашиглалтад хүлээн авсан. Гүйцэтгэлийн баталгаа болон техник хяналтын зардал татагдсан. |
| 16 | XIV.1.1.41 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Цахир сум/ | 1,270.3 | 741.3 | 12.33 | 516.7 | Гэрээний хугацаанд хэрэгжээгүй. |
| 17 | XIV.1.1.37 | Сумын төвийн доторх 1.5 км хатуу хучилттай авто зам /Архангай, Хайрхан сум/ | 996.0 | 918.0 | 45.86 | 32.1 | Ашиглалтад хүлээн авсан. Гүйцэтгэлийн баталгаа болон техник хяналтын зардал татагдсан. |
| 18 | XV.2.1.4 | Нийтийн биеийн тамирын төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 1, 2, 3, 5, 7 дугаар баг/ | 1,274.6 | 798.42 | 101.92 | 374.3 | |
| 19 | XV.2.1.6 | Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/ | 523.6 | 511.48 | 12.12 | 0.0 | |
| 20 | XV.1.3.1 | Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/ | 1,373.6 | 1,373.63 | - | (0.0) | |
| Эрх шилжүүлсэн ТАХ-ны нийт дүн | | | 38,536.7 | 23,823.5 | 1,790.3 | 12,923.0 | |
| 1 | XII.1.1.150 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Цэнхэр сум/ | 893.4 | 893.4 | | - | |
| 2 | XVI.1.43 | Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл /Улсын хэмжээнд/ | 2,689.1 | 2,673.1 | | 15.9 | |
| 3 | XII.1.1.149 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | - | - | | - | |
| 4 | XI.1.10 | Өгий нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Архангай/ | 1,398.4 | 1,398.4 | | - | |
| 5 | XII.1.1.79 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 8 дугаар цэцэрлэг/ | 1,257.2 | 703.7 | | 553.5 | |
| 6 | XII.1.1.97 | Цэцэрлэгийн барилга, 50 ор /Архангай, Цэцэрлэг сум/ | 801.1 | 801.1 | | - | |
| 7 | XIV.1.1.64 | Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэрхийн цагаан нуур хүртэлх хатуу хучилттай авто зам, 13 км /Архангай, Тариат сум/ | 6,706.1 | 5,475.2 | | 1,230.9 | |
| 8 | XIV.1.1.32 | Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Дарви, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн, Цэцэг сум, Архангай, Өгийнуур сум/ | 3,300.0 | 681.4 | | 2,618.6 | Аймагт хэрэгжээгүй. |
| 9 | XIX.1.11 | Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан | 627.0 | 602.2 | | 24.8 | |



| | | | | | | | |
|-------------------------------|------------------------|--|------------------|------------------|-----------------|------------------|---|
| | | хангамж, дэд бүтэц /Архангай, Эрдэнэбулган сум/ | | | | | |
| 10 | XV.1.1.3 | Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/ | 1,000.0 | 1,000.0 | | - | |
| 11 | XVIII.1.1 | Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/ | 399.4 | 196.7 | | 202.7 | Газрын байршил тодорхойгүйгээс ажил хийгдээгүй. |
| 12 | XXIII.1.1 | Архангай аймаг дахь шүүхийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | 3,469.9 | 2,922.6 | | 547.3 | |
| 13 | XVII.1.1 | Бэлчээрийн усан хангамж /Бүсүүд/ | 94.8 | 94.8 | | - | |
| 14 | XIV.1.1.9 | Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам, 28.5 км /Хангайн бүс/ | 17,989.4 | 4,746.0 | | 13,243.4 | |
| 15 | XVI.1.2 | Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр, 1 дүгээр үе шатыг аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/ | 51.8 | - | | 51.8 | Ажлын бодит гүйцэтгэл гараагүй |
| 16 | XIX.1.7 | Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/ | 1,703.8 | 1,687.1 | | 16.7 | |
| 17 | IV.1.4.1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Бүсүүд/ | 1,279.0 | 866.0 | | 413.0 | Сувилахуйн сургуулийн цогцолборын барилгын ТЭЗҮ зураг төсөв хийгдээгүй. |
| Эрх шилжээгүй ТАХ-ны нийт дүн | | | 43,660.4 | 24,741.7 | - | 18,918.6 | - |
| 37 | Нийт ТАХ-ны дүн | | 82,197.09 | 48,565.23 | 1,790.25 | 31,841.61 | - |

**ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ №2**

Эрх шилжүүлсэн ТАХ-ий гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн задаргаа

/сая төгрөгөөр/

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт | Барьцаанд байршуулсан | Техникийн хяналтад | Зохиогчийн хяналтад | Нийт олгосон санхүүжилт |
|----|--|---------------------------------|-----------------------|--------------------|---------------------|-------------------------|
| 1 | Нийтийн биеийн тамирын төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 1, 2, 3, 5, 7 дугаар баг/ | 798.42 | 101.92 | | | 900.34 |
| 2 | Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/ | 511.48 | 12.12 | | 37.00 | 560.60 |
| 3 | Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/ | 1,373.63 | | | | 1,373.63 |
| 4 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Булган сум/ | 1,180.1 | 73.93 | | 19.80 | 1,273.83 |
| 5 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.5 км /Архангай, Цахир сум/ | 741.3 | 12.33 | | | 753.65 |
| 6 | Сумын төвийн доторх 1.5 км хатуу хучилттай авто зам /Архангай, Хайрхан сум/ | 918.0 | 45.86 | 12.33 | 19.80 | 995.99 |
| 7 | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ | 4,389.4 | 1,261.37 | 59.93 | | 5,710.73 |
| 8 | Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 65.8 км /Архангай, Ихтамир, Чулуут сум/ | - | | | | - |
| 9 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/ | 888.3 | 20.61 | | 3.58 | 912.44 |
| 10 | Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/ | 1,136.9 | 20.64 | | 69.32 | 1,226.90 |



| | | | | | | |
|-----------------|---|------------------|-----------------|--------------|---------------|------------------|
| 11 | Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ | - | | | | - |
| 12 | Дотуур байрны барилга, 100 ор /Архангай, Төвшрүүлэх сум/ | 926.03 | 16.81 | | - | 942.84 |
| 13 | Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/ | 1,635.16 | 29.68 | | 14.84 | 1,679.68 |
| 14 | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 5 дугаар цэцэрлэг/ | 2,421.95 | 43.96 | | 21.98 | 2,487.90 |
| 15 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өгийнуур сум/ | 1,183.63 | 21.49 | | 10.74 | 1,215.86 |
| 16 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Өлзийт сум/ | 1,183.67 | 32.23 | | - | 1,215.90 |
| 17 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 14 дүгээр цэцэрлэг/ | 984.33 | 17.87 | | - | 1,002.20 |
| 18 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар цэцэрлэг/ | 880.43 | 15.98 | | 7.99 | 904.40 |
| 19 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хашаат сум/ | 1,443.61 | 31.84 | | 10.53 | 1,485.98 |
| 20 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 9 дүгээр цэцэрлэг/ | 1,160.99 | 31.61 | | - | 1,192.60 |
| Нийт дүн | | 23,757.39 | 1,790.25 | 72.26 | 215.58 | 25,835.49 |

